

**2019.07.22-НЫ ӨДРИЙН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ШУУРХАЙ ХУРЛААС ӨГСӨН ҮҮРГИЙН ШИНЭЧИЛСЭН БИЕЛЭЛТ**

2019.08.02

№21

Дархан

№	Өгөгдсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн	Хэрэгжилт
1	35,36 дугаар брак байшингийн буулгалтыг Тэргүүлэгчид дэмжсэн. Буулгалтын ажлыг анхааръя.	/ОНӨГ/	2019 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн Засаг даргын зөвлөлийн хурал дээр 62, 63 дугаар брак байрыг буулгах ажлын төсвийг танилцуулсан. Барилга тус бүрийг буулгах зардлыг 9,9 сая төгрөг байхаар шийдвэрлэсэн. 62 дугаар брак байрыг буулгах ажил эхэлсэн. Буулгалтын ажил 20 хувьтай явагдаж байна.
2	“Шарилжгүй Дархан” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд багууд идэвхтэй оролцох	/Дархан сум/	Багийн Засаг дарга нарын ээлжит хурал дээр “Шарилжгүй Дархан” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд багууд аж ахуйн нэгж байгууллагуудыг идэвхтэй оролцуулах тухай чиглэл өгсөн.
3	Наадмын санхүүгийн тайланг нэгтгэж, өр төлбөрийг өгч барагдуулах	/СТСХ/	Үндэсний их баяр наадмыг зохион байгуулахтай холбоотой хөрөнгийн 2 захирамж гарсан. АЗДТГ-аас 50,0 сая төгрөгийн санхүүжилтийг ажлын хэсгүүдэд олгосон. Баяр наадмын үеэр тусгай зөвшөөрөл олгож бүрдүүлэх МХГ, Цагдаагийн газар нийт 21,5 сая төгрөгийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн. Үүнээс 10,9 сая төгрөгийн санхүүжилтийг олгоогүй байгаа ба одоогийн байдлаар морины уралдааны салбар хороо, тохижилт, реклам чимэглэлийн ажлын хэсгүүд өгөөгүй байна. Нийт 8 ажлын хэсэг тайлангаа өгөхөөс 5 ажлын хэсэг тайлангаа өгөөгүй байна.
4	Төсөл, хөтөлбөр дээр гэрээ байгуулаагүй компани байна. Гэрээ байгуулж дуусах	/ХОХБТХ/	Тайланд хугацаанд дараах ажлын гэрээг байгууллаа. Үүнд: -Хүслийн хотхонд байрлах 23 дугаар цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн ажил, - 6,7 дугаар багийн авто зам -5 дугаар багийн гэр хороолол руу дэд бүтэц татах ажлын гэрээг тус тус байгууллаа.
5	Өвөлжилтийн бэлтгэл дээр анхааръя. Бичиг нь ирсэн.	/Сумд, ЗА/	Өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөг боловсруулан хавсаргав.
6	Үнэлгээний шатанд яваа, зарлагдсан, зарлагдаад буцсан, ХОХБТХ дээр үлдсэн тендерүүдийн мэдээллийг нэгтгээд танилцуулах	/ОНӨГ/	Худалдан авах ажиллагааны явцын тайланг хүснэгтээр хавсаргав.
7	100 үнээний асуудлаа шахаад явмаар байна	/ХОХБТХ/	100 үнээ нийлүүлэх гүйцэтгэгчтэй ХХААГ-ын албаны дарга Б.Оюунтөгс уулзаж, гэрээний гүйцэтгэлийг газар дээр нь шалгахад 100 толгой эх малаас 13 дутуу байсан. Иймд 09 дүгээр сарны 01-ны өдрийн дотор эх

			малын тоо толгойг бүрдүүлэх чиглэл өгсөн. 87 эх малын зургийг авч баримтжуулсан.
8	Эмнэлгийн өргөтгөлийг ХОХБТХ-тэй хамтраад эрчимжүүлэх	/НБХ/	Нийгмийн салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хийж гүйцэтгэх ажлын жагсаалтыг 2019 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 6-10/622 дугаар албан бичгээр ХОХБТХ-т хүргүүлсэн.
9	Худагны асуудлыг ХОХБТХ-тэй хамтраад эрчимжүүлэх	/Орхон сум/	2020 онд хийж гүйцэтгэх ажлын жагсаалтыг гаргаж ХОХБТХ-т хүргүүлсэн.
10	Хугацаатай, цохогдсон бичгүүдээ анхаарах	/ХЭЗХ/	Хууль зүй, дотоод хэргийн яамнаас наториатын үүргийг гүйцэтгэгчийн судалгааг 2019 оны 09 дүгээр сарын 01-ны өдрийн дотор ирүүлэх тухай албан бичгийг ирүүлсэн Орхон сумын ЗДТГ-ын дарга наториатчийн үүргийг гүйцэтгэж буй бөгөөд ээлжийн амралттай байгаа болно. АТГ-аас Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн 2018 оны тайланг цахим сайтад 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор байршуулах тухай албан бичгийг ирүүлсэн байршуулах сайт, холбогдох эрхийг авахаар ажиллаж байна.
11	Ажлын мэдээллээ тухай бүр мэдээллэдэг байх. Хэдэн шүүх хурал, хэд нь буцсан, хэдэн нэхэмжлэх ирсэн, ямар ажил шүүх дээр байгаа гээд мэдээллүүдээ танилцуулдаг болмоор байна.	/ХЭЗХ/	Аймгийн Засаг даргын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа бөгөөд Д.Уртнасангийн нэхэмжлэлтэй шүүх хуралдаанд оролцож, шүүхийн шийдвэр нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн, шүүхийн шийдвэрийг Мягмар гаригт хүлээн авлаа. Давж заалдах шатны шүүхэд гомдол гаргахаар ажиллаж байна. Иргэн Б.Батжавын нэхэмжлэлтэй захиргааны хэргийн урьдчилсан хэлэлцүүлэг болон шүүх хуралдаанд оролцсон. Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хүсэлтээр шүүх хуралдааныг 14 хоногоор хойшлуулсан.
12	Ээлжийн амралтын хуваарийг танилцуулах	/ТЗУХ/	Ээлжийн амралтын хуваарь батлах тухай аймгийн Засаг даргын 2019 оны 01-А/ дугаар захирамж, Тамгын газрын даргын 2019 оны 2-Б/17 дугаар тушаалыг хувилж аймгийн Засаг даргад хүргүүлсэн. Нийт албан хаагчдын 49 хувь нь ээлжийн амралтаа авсан, 41 хувь нь амраагүй, 3 албан хаагч ээлжийн амралтаа биеэр эдлэж дууссан байна.
13	2020 оны хөрөнгө оруулалтын ажлаа цэгцэлье.	/ХОХБТХ/	2020 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг нэгтгэх ажил хийгдэж байна.
14	9 дүгээр сард иргэдтэй	/ТЗУХ,	Иргэдтэй хийх уулзалтын тухай

	хийх уулзалтыг зохион байгуулна. Бэлтгэл хангах	ХОХБТХ/	удирдлагаас нарийвчилсан чиглэл өгнө.
15	Засаг даргын зөвлөлийн хурлыг өнөөдөр 16.00 цагт зарлаж хуралдуулах	/ТЗУХ/	Засаг даргын зөвлөлийн хурлыг 2019 оны 7 дугаар сары 22-ны өдрийн 16.00 цагт зарлан хуралдуулав. Хурлаар үндсэн 2 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Хурлын тэмдэглэлийг албажуулж удирдлагад танилцуулсан.
16	2019 оны 9 дүгээр сарын 2-6-ны өдрүүдэд ОХУ-ын Эрхүү мужийн Братск хотод ажиллах бизнес эрхлэгчдийг бэлтгэл хангуулах. Дарханд Үйлдвэрлэв, ХАҮТ-ыг дуудаж оролцуулах. Төлөвлөгөө гаргах. Цаашдаа Дарханд худалдааны төв нээнэ гэж ярьж байгаа. Ач холбогдол өгч ажиллах.	/ХОХБТХ/	Үзэсгэлэнд оролцох төлөөлөгчидтэй 7 дугаар сарын 29-ний өдрийн 15.00 цагт уулзалт зохио байгуулж нарийвчилсан чиглэлийг өгсөн. Манай аймгаас нэхий, нэхий эдлэл, сүлжмэл, ноос, ноолууран бүтээгдэхүүн, бэлэг дурсгалын зүйл, “Алтан хүнс” үйлдвэрийн архи, ургамлын цай зэрэг бүтээгдэхүүнийг сурталчлан худалдаалах 40 орчим бизнес эрхлэгчид тус үзэсгэлэн худалдаанд оролцоно. Тээврийн асуудлыг удирдлагатай ярилцаж тохиролцсон. Төлөвлөгөөний дагуу ОХУ-аас Дархан-Уул аймагт суугаа Ерөнхий Консул А.Ц.Доржиев, Гаалийн Ерөнхий газрын дарга Б.Асралт нарт бараа бүтээгдэхүүнийг ОХУ-ын хил гаалиар нэвтрүүлэхэд холбогдох дэмжлэгийг үзүүлэх тухай хүсэлтүүдийг албан ёсоор хүргүүлсэн.
17	Бизнес эрхлэгчдийг Эрхүү явахтай холбогдуулан хил гаалиар бараа нэвтрүүлэх хөнгөлөлттэй нөхцөлийг судлах	/ХЭЗХ/	Хууль эрх зүйн хэлтэст холбогдох мэдээлэл байхгүй болно. Санхүү, төрийн сангийн хэлтэс Гаалийн газрыг хариуцдаг тул тухайн хэлтсээс нь асууу тодруулах нь зүйтэй.
18	Хөрөнгө оруулалтын ажлаа үзэж танилцуулах	/ХОХБТХ/	2019 оны 07 дугаар сарын 30-ны өдөр Барилга захиалагчийн албаны Ерөнхий инженер, хяналтын инженер нартай уулзаж, хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байгаа ажлуудтай танилцаж, үүрэг чиглэл өгч ажиллалаа.
19	Санхүүжилтийн мэдээг цаасаар хэвлэж танилцуулах	/СТСХ/	Орон нутгийн төсвийн санхүүжилтийн мэдээг цаасаар гаргаж Засаг даргад танилцуулсан.

ХЯНАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

П.БАЯРСАЙХАН

НЭГТГЭСЭН:ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН

ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН:

Ц.БОЛОРТУУЛ